



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

Барилгачдын талбай 3, Утас: 7000 3959,

Факс: (976-11) 32 26 83, И-мэйл: info@gazar.gov.mn

2022.02.18 № 1/293

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛТЭЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД**

Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 74 дүгээр тушаалаар батлагдсан “Байр зүйн болон дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөх” журмын 5.4-т заасны дагуу байгууллага, аж ахуйн нэгж, иргэний шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, ажил гүйцэтгэсэн объектуудын гүйцэтгэлийн байр зүйн зургийг хийж Геодези, зураг зүйн тухай хуулийн 9.2-т заасны дагуу Геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд төвлөрүүлэхэд анхаарч ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.

Хавсралт 8 хуудастай.

ДАРГА

*А.ЭНХМАНЛАЙ*

·1522020268



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 4 сарын 12 өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь::

1.“Байр зүйн болон дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөх” журмыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Т.Болорчuluун/-т, мэдээллийн санг, хэвийн тасралтгүй үйл ажиллагаагаар хангаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар /Ц.Ганхүү/-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Журам батлах тухай” 298 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.



03 00243

Барилга, хот байгуулалтын сайдын  
2019 оны ... дугаар сарын 12. өдрийн  
74... дугаар тушаалын хавсралт

**БАЙР ЗҮЙН БОЛОН ДЭВСГЭР ТООН ЗУРАГ,  
ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН МЭДЭЭЛЛИЙН  
САНГ ХӨТЛӨХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл.**

1.1. Аймаг, нийслэлийн том болон дунд масштабын байр зүйн болон дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийг "Геодези, зураг зүйн тухай", "Хот байгуулалтын тухай", "Барилгын тухай", "Орон сууцны тухай" хууль болон бусад эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд мэдээллийн санд бүртгэх, шинэчлэх, ашиглах, хадгалахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Инженерийн дэд бүтэц бүхий том болон дунд масштабын байр зүйн болон дэвсгэр тоон зураг агуулсан мэдээллийн сан нь /цаашид Мэдээллийн сан гэх/ бусад мэдээллийн сангудын үндсэн суурь мэдээллийн сан байна.

1.3. Мэдээллийн санг үүсгэж, тогтмол шинэчлэн бусад төрийн байгууллагатай мэдээлэл солилцох үйл ажиллагаа нь Засгийн газрын 2017 оны 159 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам"-д нийцсэн байна.

**Хоёр. Мэдээллийн санд тавигдах үндсэн шаардлага.**

2.1. "Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдгийн стандарт Масштаб: 1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000 MNS 6702:2017", "Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдгийн стандарт Масштаб: 1:25 000, 1:50 000, 1:100 000 MNS 6703:2017" стандартын дагуу Мэдээллийн санг үүсгэж, бүртгэлийг хөтлөнө.

2.2. Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болох Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар нь /цаашид ГЗБГЗ3Г гэх/ Мэдээллийн санг хариуцагч байгууллага байна.

2.3. Аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан байгууллага нь /цаашид нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар буюу НХБХГ, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар буюу ГХБХБГ гэх/ аймаг, нийслэлийн хэмжээнд тус тус Мэдээллийн санг эрхлэн хөтлөгч байна.

2.4. Мэдээллийн сан нь Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоо, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2014 оны A/112 дугаар тушаалаар батлагдсан ITRF2008 эринд хийгдсэн байна.

2.6. Энэ журамд заасан эрх зүйн баримт бичиг шинэчлэгдсэн тохиолдолд түүний хамгийн сүүлд батлагдсан хувилбарыг баримтална.

**Гурав. Мэдээллийн санг хариуцагч байгууллагын үйл ажиллагаа.**

3.1. Мэдээллийн санг хариуцагч байгууллага нь мэдээллийн сангийн бүтэц зохион байгуулалт, түүнийг хөтлөх асуудлыг улсын хэмжээнд зохион байгуулна.

3.2. Мэдээллийн санг эрхлэн хөтлөгч байгууллагыг холбогдох сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангана. Үүнд:

3.2.1. Мэдээллийн сангийн хөтлөлт;

3.2.2. Мэдээллийн сангийн хадгалалт хамгаалалт;

3.2.3. Хэрэглэгчдийг мэдээллээр хангах.

3.3. Мэдээллийн сангийн архивыг улсын хэмжээнд бүрдүүлнэ.

3.4. Мэдээллийн санг хөтлөгч байгууллагаас ирүүлсэн жижүүрлэлтийг үндэслэн тодруулалтын ажлыг төлөвлөж зохион байгуулна.

**Дөрөв. Мэдээллийн санг хөтлөгч байгууллагын үйл ажиллагаа.**

4.1. Аймаг, нийслэлийн хэмжээнд хийгдэж буй геодези, зураг зүйн ажил нь хот, тосгоны төлөвлөлт болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэхэд хяналт тавина.

4.2. Геодезийн хэмжилт, зураглал инженерийн шугам сүлжээний зураглалыг "1:500, 1:1 000, 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил" БД 11-10-08, "Барилгын геодезийн ажил" БНБД 11-08-06, "Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил" БД 11-105-06, "Ус, дулаан хангамж, ариутгах татуургын сүлжээ, үерийн усны байгууламжийн геодезийн ажил" БД 11-115-16 зэргийг баримтлан гүйцэтгэсэн эсэхэд хяналт тавина.

4.3. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний гүйцэтгэсэн геодезийн хэмжилт зураглалын ажлыг тоон болон хэвлэмэл байдлаар авч Мэдээллийн санг хөтлөгч байгууллагын геодезийн инженер шалгана.

4.4. Геодезийн хэмжилт, зураглал, гүйцэтгэлийн байр зүйн зургийн ажил шаардлага хангахгүй, алдаатай бол гүйцэтгэгчид албан ёсоор мэдэгдэж засварлуулна.

4.5. Барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг шинээр барьж байгуулах болон засвар өөрчлөлт хийсний дараа гүйцэтгэлийн зураг хийгдээгүй бол гүйцэтгэгчээр нөхөн хийлгэх ажлыг зохион байгуулна.

4.6. Мэдээллийн сангийн архивыг улирал тутам бүрдүүлнэ.

4.7. Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар /НХБХГ/, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /ГХБХБГ/ нь инженерийн дэд бүтэц

бүхий байр зүйн болон дэвсгэр тоон зурагт орох шаардлагатай өөрчлөлтийг хариуцан хөтөлнө.

4.8. Мэдээллийн санд гүйцэтгэлийн зураг, хэмжилтийн өгөгдлөөр ороогүй бусад элементүүдийн бүртгэлийн жижүүрлэлтийг “Геодези, зураг зүйн тухай” хуулийн 5.8.2-д заасны дагуу тогтмол хөтөлнө.

**Тав. Мэдээллийн санг хөтлөх.**

5.1. Геодезийн хэмжилт, зураглалын ажил болон гүйцэтгэлийн байр зүйн зургийг үндэслэн мэдээллийн санг хөтөлнө. Геодезийн хэмжилт, зураглалын ажил, гүйцэтгэлийн байр зүйн зураг нь мэдээллийн сантай уялдахаар зах нийлсэн байдлаар хийгдсэн байна.

5.2. Инженерийн шугам сүлжээний ашиглалт хариуцсан байгууллагаас инженерийн дэд бүтцэд хийгдсэн өөрчлөлтийн мэдээллийг сервер сүлжээнд холбогдсон бол цаг тухай бүр, холбогдоогүй бол сар бүр солилцож ажиллана.

5.3. Зураглалын ажил, гүйцэтгэлийн байр зүйн зургийг шалгаж, актаар хүлээн авсны дараа мэдээллийн санд оруулна.

5.4. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, өөрчлөлт гүйцэтгэсэн дараах ажилд гүйцэтгэлийн байр зүйн зураг хийгдэнэ. Үүнд:

5.3.1. Газрын гадаргын өөрчлөлт;

5.3.2. Барилга байгууламж, түүний өргөтгөл, их засвар;

5.3.3. Инженерийн дэд бүтэц;

5.3.4. Явган зам талбай, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, хөшөө дурсгал, усан оргилуур, тэдгээрийн тохижилт;

5.3.5. Хороолол, хотхон, тэдгээрийн тохижилт;

5.3.6. Нисэх буудал;

5.3.7. Нефть, хийн хоолой;

5.3.8. Ашигт малтмалын зориулалтаар эзэмшиж, ашиглаж буй талбайн хаягдал, овоолго, нөхөн сэргээлт;

5.3.9. Газар тариалан, усжуулалт;

5.3.10. Бусад байгууламж /камерын сүлжээ, оршуулгын газар, гэх мэт/;

5.5. Гүйцэтгэлийн байр зүйн зургийг тоон хэлбэрээр мэдээллийн санд объект тус бүрээр, зөв байрлалаар нэмж оруулна. Зарим тохиолдолд объектыг солбицлоор нь мэдээллийн санд оруулж болно.

5.6. Мэдээллийн санд оруулах гүйцэтгэлийн тоон зураг нь Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны 2010 оны 402 дугаар тушаалаар батлагдсан “Хот,

тосгоны өрөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар"-ын хавсралт дахь хүснэгтэн мэдээллэлтэй хийгдсэн байна.

5.7. Зураглал болон гүйцэтгэлийн байр зүйн зургийг геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр хийлгэнэ.

5.8. Шинээр барьж байгуулсан болон өргөтгөл, их засвар хийгдсэн барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийг мэдээллийн санд бүртгүүлэхээр хүсэлт гаргах үүргийг тухайн барилга байгууламж, шугам сүлжээг эзэмшигч, ашиглагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хүлээнэ. Мэдээллийн санд бүртгүүлэхдээ Хавсралт 1-д заасан загварын дагуу хүсэлт гаргана.

5.9. Барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг ашиглалтад оруулахын өмнө тухайн талбайн гүйцэтгэлийн байр зүйн зургийг мэдээллийн санд бүртгэсэн байна. Мэдээллийн санд бүртгэсэн тухай БНБД 11-08-06-ийн хавсралт 15-д буй загварын дагуу акт үйлдэнэ. Мэдээллийн санд бүртгүүлсэн эсэхэд “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулсан комисс”-ын дарга хяналт тавина.

5.10. Гүйцэтгэлийн байр зүйн зураг, хэмжилтийн өгөгдлийг үндэслэл болголгүйгээр мэдээллийн санд өөрчлөлт оруулахыг хориглоно.

### **Зургаа. Мэдээллийн сангийн ашиглалт, үйлчилгээ.**

6.1. Мэдээллийн сангийн өгөгдлийг төрийн бусад байгууллагуудад хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулан ашиглуулна.

6.2. Мэдээллийн сан дахь Засгийн газрын 2017 оны 247-р тогтооолоор батлагдсан төрийн нууцад хамаарах мэдээллийн нууцлалын асуудлыг мэдээллийн санг хариуцагч болон хөтлөгч байгууллага хариуцна.

6.3. Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтээр мэдээллийн санг хариуцагч болон хөтлөгч байгууллага нь үйлчилгээ үзүүлнэ. Үйлчилгээ нь цахим буюу онлайн, тоон, хэвлэмэл аль аль хэлбэрээр байна.

6.4. Үйлчилгээг Архивын өрөнхий газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/168 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн архивын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г баримтлан үзүүлнэ.

6.5. Мэдээллийн сангаас байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд шаардлагатай мэдээлэл гаргах ажлыг мэдээллийн санд өөрчлөлт хийх эрх бүхий этгээд гүйцэтгэнэ.

### **Долоо. Мэдээллийн сангийн хадгалалт, архивлалт.**

7.1. Мэдээллийн сангийн архивыг улирал тутам буюу 3, 6, 9, 12 дугаар сарын ажлын сүүлийн өдөр мэдээллийн санг хөтлөгч байгууллага үүсгэнэ.

7.2. Мэдээллийн санг хөтлөгч байгууллага улирал тутам үүсгэсэн мэдээллийн санг CD, DVD-д бичин Хавсралт 2-д үзүүлсэн загварын дагуу хаяг нааж, албан ёсны тамга, тэмдгээр баталгаажуулан, зориулалтын саванд хийж лацдан албан бичгээр мэдээллийн санг хариуцагч байгууллагад хүргүүлнэ.

7.3. НХБХГ, аймгийн ГХБХБГ нь тухайн оны 7 дугаар сар, дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээллийн сангийн архивыг түүнд орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлангийн хамт ГЗБГЗЗГ-т ирүүлнэ.

7.4. НХБХГ, аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн архивын баримт материалыг зохих журмын дагуу Архив, мэдээллийн төвд хүлээлгэн өгөх ажлыг ГЗБГЗЗГ-ын Геодези, зураг зүйн хэлтэс хариуцна.

#### **Найм. Хүлээлгэх хариуцлага.**

8.1. Геодезийн хэмжилт, зураглал болон гүйцэтгэлийн байр зүйн зургийн үнэн зөв эсэхийг хэмжилт, зураглал хийсэн этгээд хариуцах бөгөөд магадлан хэмжилтээр гүйцэтгэлийн зураг алдаатай нь тогтоогдвол “Зөрчлийн тухай” хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

8.2. Мэдээллийн санд тухай бүр өөрчлөлтийг оруулах, оруулсан өөрчлөлтийн үнэн зөвийг мэдээлэл оруулсан этгээд хариуцна.

8.3. Мэдээллийн санд алдаатай, буруу мэдээлэл оруулсан этгээд түүнээс учирсан хохирлын хариуцлагыг зохих хууль, журмын дагуу хүлээнэ.

8.4. Мэдээллийн сангаас хууль бусаар мэдээлэл хуулбарлах, нийтэд тараахыг хатуу хориглох бөгөөд мэдээлэл хувилан тараасан буруутай этгээдэд учруулсан хохирлын хэмжээнээс хамааруулан зохих шийтгэл оногдуулна. Шаардлагатай тохиолдолд холбогдох шатны хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

**БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН БАЙР ЗҮЙН  
ТООН ЗУРГИЙГ МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГҮҮЛЭХ  
ХҮСЭЛТИЙН ХУУДАС**

Дугаар 20.....-

Хүсэлт гаргагч Байгууллага, ААН, иргэний нэр, утас: .....  
 Барилга, байгууламжийн байршил.....  
 Барилга, байгууламжийн төслийн нэр.....  
 Барилга, байгууламжийн төрөл, тоо, хэмжээ.....  
 Байр зүйн зургийг гүйцэтгэсэн ААНБ-ын нэр:.....  
 Хөрөнгө оруулалтын байдал: Хувийн / Төсвийн / Зээл тусlamж / Бусад /доогуур нь зурах/

Бүрдүүлэх материалын бүрдэл		Тайлбар
1	Байр зүйн зураг хэвлэмэлээр	Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжээр зураг хийлгэнэ.
2	Байр зүйн зураг тоон байдлаар /CD/	
Хүсэлт шийдвэрлэлт		
Зөвхөн албан хэрэгцээнд		
Олгосон: .....оны ..... сарын..... өдөр. Үйлчилгээний ажилтны нэр: .....		

